

## **ТХТ ХУУС ТББ-ын 1 жилийн ажлын товч тайлан**

Г.Батсайхан миний бие 2016 оны 4 сарын 1-нд тус байгууллагын гүйцэтгэх захирлын ажлыг хүлээн аваад 1 жил гаруй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд хийсэн ажлаа товч, тодорхой тайлагнавал:

### ***Нэг. Дотоод ажлын талаар:***

1. Байгууллага дансандаа мөнгөгүй байсан тул сард 850 мянган төгрөгний түрээс төлдөг байрнаас сард 450 мянган төгрөг төлдөг байранд нүүн орж төвхөнлөө
2. Шинэ байрандаа ороод бичиг баримтуудаа өөрт эвтэйхнээр эмхэлж, зарим эвдэрсэн ширээг засаж, санхүүгийн баримтуудын он оноор нь ялган тусгай хайрцагт савлан эмхэлж, ажлын хэвийн нөхцөлийг бүрдүүлэв.
3. Офисыг интернеттэй холбуулан, гэрээг байгуулан ажилд орууллаа.
4. Байгууллагын домейн нэрийг дахин шинээр авч, шинээр вэб сайт хийлгэн ашиглалтанд оруулаад байна. Одоо түүнийгээ дахин уншиж сайжруулах ажил хийхээр төлөвлөж байна. Вэб сайтыг хуучин нэрээр авсан.

### ***Хоёр. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр хийсэн ажил:***

1. ШУТИС-ын ГУУСургуулийн уул уурхайн менежментийн 3 оюутныг ХУУ-н чиглэлээр мэргэшүүлэх, тэдний дадлагыг хийлгэх ажлыг багш нартай нь болон тухайн оюутантай тохиролцсоны үндсэн дээр офис дээр 1 сар ажиллуулж Монголд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын жагсаалт, олборлож буй ашигт малтмалын төрөл, тэдгээрийн байршил, хаяг, утас бүхий мэдээллийг түүлгэн аймаг, сум бүрээр гаргуулан байгууллагын мэдээллийн сангийн эхлэлийг бий болголоо
2. ХУУ-н шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан боловсруулж, түүнийг оноогоор дүгнэх аргачиллыг хийн Удирдах зөвлөлийн гишүүдэд илгээн саналыг авч эцэслэн гаргалаа.
3. Уул уурхай эрхлэгчдийн хариуцлагын төвшин тогтоох талаар хамтарч ажиллах, энэ ажлыг хариуцан ажиллах байнгын ажиллагаатай комисс байгуулах талаар УУХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, АМХЭГ, ОУИТС ТББ, МХАҮТ, ТАН эвсэл, УУА, ШУТИС-ийн ГУУСургуультай очиж уулзалт хийлээ. Энд УУ-н ассоциацаас бусад байгууллага хамтарч ажиллахад бэлэн байгаага илэрхийлсэн. Гол байгууллага болох УУХҮЯ-ны ярилцаж тохиролцсон хүмүүс ажлаа өөрчилчихөөд тохиролцсон ажил зогсонги байдалд орчихоод байна.
4. Канадын элчин сайдын яамны санхүүжилтээр, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар ХУУ-н гарын авлагыг турших, сургагч багш бэлтгэх чиглэлээр нийт 36 981 380 төгрөгний ажлыг гүйцэтгэж дараах үр дүнд хүрлээ:
  - Хариуцлагатай уул уурхайн гарын авлага боловсруулж дууслаа. Уг нь төслийн зорилго нь тэдний өмнө нь захиалж хийлгэсэн байсан гарын авлагыг сургалт хийн туршиж, сайжруулах байсан боловч уг гарын авлагаас авч ашиглах зүйл байгаагүй тул бүгдийг шинээр бичсэн болно. Энэ гарын авлага Уул уурхайн тухай ерөнхий ойлголт, Хариуцлагатай уул уурхайн ойлголт түүний зарчмуудыг хэрэгжүүлэх аргачилал болон уул уурхай хариуцлагатай байхад төрөөс тавих хяналтын тухай агуулгыг тусгасан 100 орчим хуудастай

- бүтээл болсон. Одоо түүнийг хэвлүүлэх санхүүжилт олох ажлыг НҮБ-н хөгжлийн хөтөлбөрөөс хөөцөлдөж байна.
- Хариуцлагатай уул уурхайн сургалт явуулахад зориулсагдсан сургалтын дэлгэрэнгүй хөтөлбөрийг боловсрууллаа.
  - Уг гарын авлагын бүтэц, агуулгыг орон нутагт байх уул уурхайн оролцогч талууд хэрхэн хүлээн авч байгаа байдал, ХУУ-н зарчим шалгуур үзүүлэлтийг сайжруулах талаарх санаа бодлыг авах зорилгоор Дундговь, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад нийт 80 хүнд сургалт явуулж ХУУ-н шалгуур үзүүлэлтээ хэлэлцүүлээ. Тэднээс гарсан зарим саналыг шалгуур үзүүлэлтдээ тусгаж гарын авлагаа сайжруулж байлаа
  - Гарын авлагаа ШУТИС-ийн ГУУСургуулийн багш нарын дунд хэлэлцүүлж, тэднээр техникийн редакци хийлгэлээ. Мөн тэднээс 10 багшийг сургагч багшаар бэлтгээд байна.
5. ХУУ-н чиглэлээр магистрын ажил хийж байгаа суралцагч Б.Мөнхбаяртай тохиролцож ХУУ-н талаар бусад улс орнуудад юу хийгдэж байгааг судлуулж, манай боловсруулсан шалгуур үзүүлэлтийг олон улсын төвшинд хийгдэж байгаа ажилтай харьцуулж үзэх судалгаа хийлгэж байна.
  6. Уул уурхайтай холбоотой төрөл бүрийн уулзалт, хэлэлцүүлэг, семинарт оролцож, хийж байгаа ажлаа танилцуулах, санхүүжилт олох, талаар ажиллаж байна.
  7. “Усны нөөцийн бүлэг 2030” олон улсын байгууллагын Монгол дахь салбарын удирдах зөвлөлийн гишүүнд орж ажиллаж байна. Энэ шугамаар 4-р сард Перу улсад болсон “Уул уурхай ба ус” сэдэвт уулзалтанд оролцоод тэнд Монголд ХУУ хэрхэн хөгжиж байгаа талаар илтгэл тавиад ирсэн.
  8. ШУТИС-ийн ГУУСургуультай хамтарч сургалт явуулах, ХУУ-н стандарт боловсруулах, уул уурхай эрхлэгчдийн хариуцлагын түвшинг тогтоох ажлыг хамтарч хийхээр гарээ байгуулаад ажиллаж байна.
  9. УИХ-д хариуцлагатай уул уурхайн лобби бүлэг байгуулагдсан тухай сонсоод тэдэнтэй уулзах гэсэн боловч уулзаж болохгүй байна. Тэдэнтэй мөн заримых нь туслахтай утсаар холбогдож чадсан боловч тэдний зүгээс уулзах хүсэл сонирхол байхгүй байгаа юм шиг байна.

### ***Гурав. Цаашдын зорилт:***

1. Хариуцлагатай уул уурхайн стандарт гаргах. Стандартын үндэслэлийг боловсруулаад УУХҮЯ-нд хүргүүлээд байгаа
2. Уул уурхай эрхлэгчдийн хариуцлагын түвшинг тогтоож үр дүнд дүн шинжилгээ хийх
3. ХУУ-н сургалтыг аль болох ихээр явуулах

### ***Дөрөв. Санхүүгийн талаар:***

1. Канадын элчин сайдын яамны санхүүжилтээр, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар 3 удаагийн нийт 36 981 380 төгрөгний ажлыг гүйцэтгэлээ. Энэ ажил нь хөдөө орон нутагт сургалт явуулахад зориулагдсан ба энэ нь багш нарын томилолт, сургалтын хэрэглэгдэхүүн, суралцагсдын хөдөөнөөс ирэх буцах унаа, хоол, буудалд зарцуулагдахаар төсөвлөгдсөн зардал байдаг. Гэхдээ эндээс илүүчилж дараах асуудлыг шийдээд байна:

- 2016-4 сараас 2017 оны 4 сар хүртлэх байрны мөнгөнд 4 сая төгрөгийг төлөөд байна
- Одоо 2017 оны 10 сар хүртэл байрны мөнгө 2 сая төгрөгийг төлөхөөр хадгалж байна
- 2. Банкинд 3 данстай байсан ба тэд сар бүр үйлчилгээний шимтгэл төлөөд байж байсныг хаалгаад одоо байгууллага 1 данстай болсон
- 3. Нийгмийн даатгалын, хувь хүний орлогын албан татварын тайланг сар бүр, байгууллагын тайлан балансыг хагас жил бүр хуулийн дагуу төлж байна.
- 4. Одоогоор байгууллага Арвинбаяр удирдах зөвлөлийн дарга байх үед тавигдсан 4,3 сая төгрөгний татварын өртэй байдаг юм байна. Үүнээс төлж багасгаж чадсангүй. Гадны төслийн тэндэрт ороход энэ өр саад болоод байх шинжтэй юм байна.

Одоогийн удирдах зөвлөлийн дарга ажлаа өгөх хүсэлтээ удирдах зөвлөлд сүлжээгээр тавьчихсан байгаа. Би бас өөрийнхөө оронд гүйцэтгэх захирал хийх чадварлаг, хүсэл сонирхолтой, залуу хүн олж тавихаар эрэл хийж байна. Харин би өөрөө түүнийг чиглүүлээд УЗ-н даргын ажлыг хийж болно гэж үзэж байгаа. Гэхдээ хэн нэгэн энэ ажлыг авна гэвэл би өрсөлдөхгүй байх болно.

**Товч тайланг бичсэн гүйцэтгэх захирал Г.Батсайхан.**

**2017 оны 5 сарын 15 ны өдөр**